




ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

"Орон нутгийн хөгжлийн сангийн 2014 оны зарцуулалтын байдал"

ҮАГ– НАГ/2015/03-НА-ХөААГ

МУ-ын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан

Хэрэгжсэн төсөл арга хэмжээг гэрээний үнийн дүнгээр ангилвал дараах байдалтай байна.



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖИХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛИЙГ БОДИТОЙ ХИЙХГҮЙ БАЙНА.

2015 оны 05 дугаар сар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2015 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 6/20

Мөрөн

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛАХ
ТУХАЙ

УИХ-ын төсвийн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол, МУ-ын Ерөнхий аудиторын 2014 оны 121, Аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2015 оны 04 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Орон нутгийн хөгжлийн сангийн 2014 оны зарцуулалтын байдал"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Нийцлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтэст тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллан үр дүнг 2015 оны 12 дугаар сарын 1-ний дотор багтаан аймгийн Аудитын газарт ирүүлэхийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Т.Болдбаатар, Засаг дарга А.Эрдэнэбаатар, аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Х.Ган-Очир нарт зөвлөсүгэй.
4. Зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын менежер Г.Эрдэнэчимэг, ахлах аудитор Б.Тэгшдэлгэр нарт даалгасугай.

АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ОЮУНГЭРЭЛ

070091

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн: ХөААГ-ын Нийцлийн аудитын баг Тэргүүлэх аудитор Г.Оюунгэрэл Утас: 89905871 Аудитын менежер Г.Эрдэнэчимэг Утас: 99016320 Багийн ахлагч : Ахлах аудитор Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Багийн гишүүн: Шинжээч А.Ууганбаяр Утас: 88866993 2015 оны V сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70384043 дугаарын утсаар харилцана уу.ХАЯГ: Мөрөн сум Аймгийн ЗДТГ-ын “А” корпус 3 давхар	Товчилсон үгийн жагсаалт Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй Бүлэг 1. Сумдад тухайн жилийн давсан орлогыг сумын ОНХС-ийн эх үүсвэр болгон төлөвлөж, хөрөнгө оруулалтад шингээх боломжийг алдаж байна. 1.1. Сумдын ОНХС-г зөвхөн аймгийн ОНХС-аас олгосон орлогын шилжүүлгээр бүрдүүлсэн ба бусад боломжийг бүрэн тооцож ОНХС-ийн эх үүсвэр болгож төлөвлөхгүй байна. 1.2. ОНХС-аас 2014 онд аймгийн ОНХС-д хуваарилагдсан эх үүсвэрээс 3931,4 сая төгрөгийг дутуу олгосон байна. Бүлэг 2. Орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдээгүй нийт 1159,9 сая төгрөгийн өртөгтэй төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын жагсаалтад оруулж баталсан байна. 2.1. Иргэдийн саналаар эрэмбэлэгдсэн ажлууд нь тэр бүр ард иргэдийн нийтлэг эрх ашигт нийцсэн, орон нутгийн тулгамдсан асуудлыг шийвэрлэсэн үйл ажиллагаа болоогүй байна. 2.2. ТЭЗҮ болон төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцооллыг бүрэн хийж чадахгүй байна. 2.3. Иргэдийн саналаар дэмжигдээгүй нийт 1159,9 сая төгрөгийн өртөгтэй төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын жагсаалтад оруулж баталсан байна. 2.4. Жагсаалтад орж ИТХ-аар батлуулаагүй 41,7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. 2.5. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулсан байна. 2.6. ОНХС-ийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт бодит байдалтай нийцэхгүй байна. Бүлэг 3: ОНХС-ийн гүйцэтгэлд тавих хяналт, үнэлгээ хангалтгүй байна. 3.1. ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжилтийг иргэдэд ил тод нээлттэй мэдээллэж байна. 3.2. Захиалагчийн хяналт тавих ажлын хэсэг томилсон боловч хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна. 3.3. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэн, иргэний нийгмийн байгууллагууд хамтран хяналт тавьж, үнэлгээ өгөхгүй байна. 3.4. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн 82,8%-ийг хэрэгжүүлж ажилласан байна. 3.5. Төрийн байгууллагууд Шилэн дансны мэдээллийг Засгийн газрын 2014 оны 384 тоот тогтоолоор баталсан “Журам”-д заасан агуулга, нийтлэг стандартад нийцүүлэн тавьж хэвшээгүй байна. 4. САНАЛ АСУУЛГЫН ДҮН 5. ДҮГНЭЛТ 6. ЗӨВЛӨМЖ
--	--

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчилсон үг	Тайлбар
МУ	Монгол улс
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
АИТХ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БИНХ	Багийн Иргэдийн нийтийн хурал
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
МУЗЗНДНТУТХ	Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ААН	Аж ахуйн нэгж

Ерөнхий зүйл

Аудитын зорилт

Орон нутгийн хөгжлийн сангийн 2014 оны хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтийн байдал хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулан дүнг АИТХ, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг хууль, журамд заасан нэр төрлөөр нь бодитой төлөвлөж бүрдүүлсэн эсэх
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасан журмын дагуу зарцуулсан эсэх
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх

Аудитын явцад "Шилэн дансны тухай" хуулийн хэрэгжилтийн байдалд хяналт хийж, тайлагнав.

Аудитын хамарсан хүрээ

Аудитыг батлагдсан хуваарийн дагуу Орон нутгийн хөгжлийн санд 2014 онд улсын төсвөөс хуваарилж олгосон шилжүүлэг болон бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн хөрөнгийг хэрхэн зарцуулсан талаар тэдний гүйцэтгэсэн ажлын тайлан болон бусад холбогдох материалд тулгуурлан гүйцэтгэсэн. Бүх сумдын ОНХС, аймгийн ОНХС-ийн 2014 оны үйл ажиллагааг хамруулан шалгав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Төрийн нууцын тухай хууль
- Улсын их хурал, засгийн газрын холбогдох тогтоол, шийдвэрүүд, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан дүрэм, журам
- Монгол улсын статистикийн хорооноос гаргасан мэдээ, судалгаа, төрийн албаны зөвлөл, аймгийн салбар зөвлөлөөс гаргасан тогтоол шийдвэр
- Төрийн албаны салбар зөвлөлөөс гаргасан мэдээлэл
- Холбогдох бусад хууль, журмууд

Аудитын арга зүй

Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан Төрийн сангийн тогтолцоонд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, түүнийг дагалдан гаргасан эрх зүйн актуудын хүрээнд хэрэгжүүлэгч байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, санал асуулга, лавлагаа, тодруулга авах, байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх, үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн зорилтот арга хэмжээнээс түүвэрчлэн шалгах бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулан ажиллав. Аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулан тайлан бичиж холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлж байна.

Аудит хийсэн бүрэлдэхүүн

Аудитыг аймгийн Хөвсгөл аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Оюунгэрэл удирдаж, аудитын менежер Г.Эрдэнэчимэг үе шатны болон чанарын хяналт тавьж, арга зүйгээр хангаж, ахлах аудитор Б.Тэгшдэлгэр, шинжээч А.Ууганбаяр нар гүйцэтгэсэн болно.

Үндсэн мэдээлэл

2014 онд аймгийн ОНХС-д 14245,7 сая төгрөг үүнээс сумдад 8036,3 сая төгрөг, аймагт 6209,4 сая төгрөгийн хөрөнгөөр төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан санхүүгийн дэмжлэг 3931,4 сая төгрөгөөр дутуу олгогдсон байна. ОНХС-ийн 2014 оны зарцуулалтыг шалгахад дараах сумууд ОНХС-ийн үйл ажиллагаанд өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажил зохион байгуулж үр дүнд хүрч ажилласан байна. Үүнд: Тариалан, Ренчинлхүмбэ, Баянзүрх, Улаан-уул сумууд ОНХС-ийн үйл ажиллагаандаа тодорхой ахиц гаргасан байна.

Нийцлийн аудитаар 2015.03.11-нээс 04.20-ныг дуустал бүх сумдад ажиллаж сумдын ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын байдал болон санал асуулга явуулсан талаар газар дээр нь хяналт хийж бүрдүүлсэн баримт материалыг шалгахад сумууд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхийн тулд санал асуулга явуулсан байна.

БҮЛЭГ 1

- Сумдад тухайн жилийн давсан орлогыг сумын ОНХС-ийн эх үүсвэр болгон төлөвлөж, хөрөнгө оруулалтад шингээх боломжийг алдаж байна.

1.1. Сумдын ОНХС-г зөвхөн аймгийн ОНХС-аас олгосон орлогын шилжүүлгээр бүрдүүлсэн ба бусад боломжийг бүрэн тооцож ОНХС-ийн эх үүсвэр болгож төлөвлөхгүй байна.

ОНХНС-аас Хөвсгөл аймгийн ОНХС-д 2014 онд 12863,7 сая төгрөгийн "орлогын шилжүүлэг"-ийг хуваарилсан ба аймгийн СТСХ-ээс дээрх орлогын шилжүүлгийг Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан аргачлалын дагуу тооцсон байна. Нийцлийн аудитаар аймгийн СТСХ-ийн төсвийн орлого хариуцсан мэргэжилтний хийсэн тооцооллыг хянаж үзэхэд сумдын ОНХС-ийн хөрөнгийг сумдын хүн амын тоо, хөгжлийн индекс, хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, татварын идэвхийг холбогдох байгууллагуудын гаргаж ирүүлсэн тооцоололд үндэслэн тооцсон байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2¹ заалтыг үндэслэн аймгийн ОНХС-ийн 12863,9 сая төгрөгийн 60% буюу 7718,2 сая төгрөгийг сумдад, 40% буюу 5145,5 сая төгрөгийг аймгийн ОНХС-д тус тус хуваарилсан байна.

Аймгийн Засаг даргаас Төсвийн тухай хуулийн 60.2-т заасан дараах эх үүсвэрээс аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг бүрдүүлэн аймгийн ИТХ-ын 2013.12.05-ны өдрийн ИТХ-ын 7 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2013 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан журмын холбогдох заалтуудтай нийцэж байна. 2014 онд ОНХС-нд 2 удаа аймгийн ИТХ-ын хуралдаанаар тодотгол хийснийг хүснэгтээр харуулбал:

/мян,төг/

№	Үзүүлэлт	АИТХ- 2013.12.05 7-р тогтоол	АИХТ-2014.01.20 3-р тогтоол		АИТХ- 2014.06.26 1-р тогтоол	Нийт дүн
			Давсан орлого	Дансны үлдэгдэл		
1	Сумдын дүн	7718239,0	307445,7	0	+10694,0	8036378,7
2	Аймгийн ОНХС	5145491,9	290271,2	766380,7	+7129,0	6209272,7
3	Нийт дүн	12863730,9	597716,9	766380,7	+17823,0	14245651,5

УИХ-ын 2014.12.18-ны өдрийн нэгдсэн чуулганаар улсын төсөвт тодотгол хийсэнтэй холбогдуулан Сангийн сайдын 2014.12.24-ны 4-1/6844 албан тоотоор Хөвсгөл аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 11997,6 сая төгрөг болгон 866,1 сая төгрөгөөр бууруулан тодотгол хийж ирүүлсэн байна. Аймгийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 34.2.1²-т заасныг үндэслэн 2014.12.24-нд 1/3111 тоот албан бичгээр төсөвт тодотгол хийлгэх саналаа хүргүүлсэн байна.

¹ Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн хөгжлийн санд энэ хуулийн 59.3-т заасан үзүүлэлтийг харгалзан хуваарилна.

² Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон

Аймгийн ИТХ-ын зүгээс УИХ-ын төсвийн байнгын хорооны 2014.12.18-ны 9/9901 тоот албан бичгээр “Хөвсгөл аймгийн төсөвт тодотгол хийх шаардлагагүй” гэсэн шалтгаанаар аймгийн ИТХ-аар аймгийн төсөвт тодотгол хийгээгүй байна. Энэ нь Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19-р зүйлийн 19.1³, 18 дугаар зүйлийн 18.1.2/б⁴ заалтыг хэрэгжүүлээгүй болохыг харуулж байна.

УИХ болон Засгийн газрын зүгээс төсвийн жил дуусч байгаатай зэрэгцүүлэн төсөвт тодотгол хийж байгаа нь цаг хугацааны хувьд аймгийн ИТХ орон нутагт бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлээгүй байна.

Сумдын ОНХС-г сумын ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн Сангийн сайдын 244 дүгээр тушаалаар батлагдсан маягтын дагуу сумын төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгон төлөвлөж баталсан ба эх үүсвэрийг зөвхөн аймгийн ОНХС-аас олгосон орлогын шилжүүлгээр бүрдүүлсэн байна.

Сум орон нутаг ОНХС-ийн эх үүсвэрийг бүрдүүлэх бусад боломжуудыг бүрэн тооцож төлөвлөхгүй байгаа нь нийцлийн аудитын явцад ажиглагдаж байна.

Тухайлбал: Орон нутгийн төсвийн давсан орлогыг ОНХС-ийн эх үүсвэр болгоогүй байна.

Сумдын давсан орлогыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

№	Сумдын нэр	Давсан орлого /2013 он/
1	Алаг-эрдэнэ	10,6
2	Арбулаг	28,0
3	Баянзүрх	12,8
4	Бүрэнтогтох	19,9
5	Галт	19,4
6	Жаргалант	13,9
7	Их-уул	9,8
8	Рашаант	1,9
9	Ренчинлхүмбэ	42,9
10	Тариан	42,6
11	Тосонцэнгэл	16,3
12	Төмөрбулаг	20,7
13	Түнэл	20,3
14	Улаан-уул	10,2
15	Ханх	14,3
16	Хатгал	28,5
17	Цагааннуур	19,6
18	Цагаан-уул	6,2
19	Цагаан-үүр	11,9

Хүснэгтээс харахад 617,2 сая төгрөгийг 2014 оны ОНХС-ийн эх үүсвэр болгож төлөвлөөд, орон нутгийн хөрөнгө оруулалтад зарцуулах боломжийг алдсан байна.

³ 19.1.Аймаг, нийслэлийн Хурал нь харьяалах нутаг дэвсгэртээ энэ хуулийн 18 дугаар зүйлд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ

⁴ 18.1.2/б Засаг даргын өргөн мэдүүлснээр сум, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлах;

20	Цэцэрлэг	2,3
21	Чандмань-өндөр	10,4
22	Шинэ-идэр	4,5
23	Эрдэнэбулган	5,6
24	Мөрөн	244,6
25	Нийт дүн	617,2

1.2. ОНХНС-аас 2014 онд аймгийн ОНХС-д хуваарилагдсан эх үүсвэрээс 3931,4 сая төгрөгийг дутуу олгосон байна.

2014 онд аймгийн ОНХС-д 14245,7 сая төгрөг, үүнээс сумдад 8036,3 сая төгрөг, аймагт 6209,4 сая төгрөгийн хөрөнгөөр төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан ба санхүүгийн дэмжлэг 3931,4 сая төгрөгөөр дутуу олгогдсон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

/сая.төг/

№	Сумын нэр	Санхүүжилтийн дүн	Авсан санхүүжилт			Санхүүжилтийн дутуу
			Улсын төсвийн орлогын шилжүүлэг	Дансны үлдэгдэл давсан орлого	Дүн	
1	Сумдын дүн	8036,4	5001,0	307,4	5308,5	2727,8
2	Аймгийн ОНХС	6209,3	3926,2	1079,8	5005,9	1203,3
3	Нийт дүн	14245,6	8927,2	1387,2	10314,4	3931,2

Дээрх хүснэгтээс харахад 2014 онд аймаг, сумын ОНХС-ийн санхүүжилтын 10314,4 сая төгрөгийг хүлээн авч төсөл арга хэмжээнд зарцуулж, 3931,2 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

Төлөвлөсөн төсөл арга хэмжээ тухайн ондоо хэрэгжих боломжгүй болсон шалтгаан нь Сангийн яамнаас санхүүгийн дэмжлэгийг 100% олгоогүй, жилийн эхэнд төсвийн орлогын бүрдүүлэлттэй уялдуулахгүй, гүйцэтгэлийн явцад удаа дараа төсвийн тодотгол хийсэнтэй холбоотой гэж үзэж байна. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлуудыг жилийн эхэнд төлөвлөж, ИТХ-аар батлуулан, худалдан авах ажиллагааг зохион байгуулан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байна.

Гэрээнд зааснаар ажлаа дуусгаад хүлээлгэн өгсөн боловч, санхүүжилтээ бүрэн аваагүй аж ахуйн нэгжүүд нилээд байгаа ба аймаг сумдын ОНХС-ийн хэмжээнд 2.4 тэрбум төгрөгийн өртэй байгаа нь нийцлийн аудитаар илэрч байна. Дээрх өрийг ОНХС-ийн санхүүгийн тайланд "өглөг"-өөр бүртгээгүй байна. /Хавсралт№-01/

БҮЛЭГ 2

- **Орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдээгүй нийт 1159,9 сая төгрөгийн өртөгтэй төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын жагсаалтад оруулж баталсан байна.**

2.1. Иргэдийн саналаар эрэмбэлэгдсэн ажлууд нь тэр бүр ард иргэдийн нийтлэг эрх ашигт нийцсэн, орон нутгийн тулгамдсан асуудлыг шийвэрлэсэн үйл ажиллагаа болоогүй байна.

Сангийн сайдын 2012 оны 244 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-аар аймаг, сумын засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг боловсруулж ИТХ-д өргөн мэдүүлэх ба ОНХС-аар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг төлөвлөхөд журмын 6.3-т заасныг⁵ баримтлахын зэрэгцээ “төсвийн төслийг боловсруулахад иргэдийн оролцоог хангаж ажиллана” гэж заасны дагуу иргэдээс санал авах, эрэмбэлэх үйл ажиллагааг шат шатанд зохион байгуулсан байна. Нийцлийн аудитаар иргэдээс ирүүлсэн саналуудтай танилцахад: Иргэд орон нутагт нэн тэргүүний хэрэгцээтэй, ард иргэдийнхээ нийтлэг эрх ашгийг хангах, сум орон нутгийнхаа хөгжлийн хөтөлбөртэй уялдсан саналуудыг тэр бүр гаргаж ирж чадахгүй байгаа нь харагдаж байна.

Энэ нь нэг талаас Төсвийн тухай хуулийг иргэдэд сурталчлах, төсөв төлөвлөх, бүрдүүлэх хуваарилах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах чиглэлээр иргэдэд тасралтгүй боловсрол олгох ажлыг эрчимжүүлэх, нөгөө талаас иргэд өөрсдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх бүх сувгаар мэдээлэл олж авах, санал асуулга авах үйл ажиллагаанд ажил хэрэгч хандаж идэвхитэй оролцохгүй байгааг илэрхийлж байна.

Аймгийн ОНХС-ийн хувьд:

2014 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт гаргахын тулд аймгийн Засаг даргын 2013.05.14-ны 1/1076 тоот албан тоотыг сумдын Засаг дарга нарт хүргүүлэн орон нутгийн хэмжээнд иргэдээс санал авах арга хэмжээг журмын дагуу зохион байгуулж 2013.06.30-ны дотор хариу ирүүлэхийг даалгасан байна.

Аудитаар аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх ажлын санал асуулгын баримт материалыг хянаж үзэхэд нийт 16 сумаас санал асуулга зохион байгуулж, жагсаалт гарган албан тоотоор аймгийн ЗДТГ-ын ХБХ-т ирүүлсэн байна. Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтний боловсруулсан мэдээллээс харахад 23 сум 1 тосгонд санал асуулгын хуудас хүргэн 15 сумын 4000 орчим

⁵ 6.3.3 хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх

6.3.6 зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийг өөр эх үүсвэртэй давхардуулахгүй байх

иргэдийн саналыг авсан, мөн цахим хэлбэрээр 600 орчим иргэн саналаа өгсөн гэж байгаа боловч энэ нь баримтаар нотлогдохгүй байна.

Хөгжлийн бодлогын хэлтсийн тухайн ажил хариуцсан мэргэжилтэн Д.Дамдиндорж санал асуулга явуулсан ажлын баримтуудыг журмын дагуу цэгцэлж, архивын хадгаламжийн нэгж үүсгээгүй байна. **Тухайлбал:** Сумдаас ирүүлсэн материал нь хуралд оролцсон иргэдийн ирц, засаг даргын тамгын газарт эрэмбэлж зохион байгуулсан ажлын хэсгийн тэмдэглэл зэрэг холбогдох нотлох баримтгүй байна.

Сумдын ОНХС-ийн хувьд: Санал асуулгыг зарим сумдад нэр төдий явуулсан нь харагдаж байна. Тухайлбал, Рашаант сумын бүх багуудын БИНХ-ын тогтоолын хавсралт болох тухайн багийн иргэдийн саналаар дэмжигдсэн ажлын жагсаалт адилхан байна.


Нийцлийн аудитаар дараах зөрчил илэрч байна. Үүнд:

- Аудитаар иргэдээс ирүүлсэн саналыг сумдын гаргасан мэдээлэл, архивын баримт 2-ыг тулган шалгахад баримтад нэгтгэгдсэн саналын хуудасны тоо, хурлын ирцийн талаарх мэдээллүүд хоорондоо зөрүүтэй,
- БИНХ-ын материалуудыг журам, зааварт заасны дагуу бүрдүүлж, архивын нэгж болгоогүй,
- Иргэдээс гарсан саналыг харгалзахгүйгээр тодорхой хэдэн ажлуудыг бүх багийн ИНХ-ын тогтоолоор баталгаажуулан хуурамч баримт бүрдүүлсэн байна.

Дээрх зөрчлүүдийг сумдаар харуулбал:

№	Сумдын нэр	Зөрчлийн утга
1	Рашаант	• Баг бүрээс ирүүлсэн жагсаалт нь бүгд адилхан ажлуудыг санал болгосон. Энэ байдлаас харахад санал асуулга явуулах ажлыг зохион байгуулсан боловч ОНХС-ийн хөрөнгөөр зарцуулах ажлуудыг төлөвлөхөд иргэдийн саналыг үндэслэл болгоогүй харагдаж байна.
2	Их-уул сум	• Санал асуулга явуулсан ажлын баримтуудыг үдэж цэгцэлж ажлын баримт болгоогүй байна.
3	Түнэл сум	• Саналын хуудсуудын тоо зөрүүтэй.
4	Чандмань-өндөр сум	• Баримт материалыг цэгцэлж үдэж архивын нэгж болгоогүй, • БИНХ-ын хуралд орлцсон хүмүүсийн гарын үсгээр баталгаажсан жагсаалт байхгүй. • Хурлын тэмдэглэл байхгүй байна.
5	Эрдэнэбулган сум	• Иргэдийн оролцоог бүрэн хангаж, санал асуулга явуулж чадаагүй, нийт санал өгсөн иргэдийн тоо нийт хүн амын 15,4%-ийг эзэлж байна. • Хурлын дэлгэрэнгүй тэмдэглэл байхгүй байна.
6	Алаг-эрдэнэ	• Баг хорооны хурлын тэмдэглэлийг бүрэн хөтлөөгүй байна. • Хэдэн хүн санал өгсөн нь тодорхойгүй байна. • 5-р багийн иргэдийн санал авсан баримт материал байхгүй байна.

Нийцлийн аудитаар иргэдийн дунд явуулсан санал асуулгын **“ОНХС-ийн асуудлыг хэлэлцэх баг, хорооны иргэдийн нийтийн хуралд та оролцож байсан уу?”** гэсэн асуултанд иргэд дараах байдалтай хариулж байна.



Дээрх асуултад санал асуулгад оролцсон иргэдийн 44% нь “хааяа” оролцдог гэсэн хариултыг өгсөн байна. Энэ байдлаас төрийн байгууллага, албан хаагчдын зүгээс тухайн ажлыг хууль журмын дагуу зохион байгуулж байгаа боловч иргэд идэвхитэй оролцохгүй байгаа

байдал харагдаж байна.

Иргэдийн санал өгсөн байдалтай танилцахад тухайн орон нутагт ач холбогдол багатай, сумын иргэдийн нийтлэг эрх ашигт нийцээгүй саналуудыг гаргаж байгаа, нөгөө талаас нэг ажлыг дэмжих зорилгоор хүмүүсийг цуглуулах зэрэг сөрөг үр дагавар гарч байна гэж зарим сумдын багийн Засаг дарга болон холбогдох албан тушаалтнууд тайлбарлаж байна. Энэ байдлаас харахад ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих ажлын жагсаалтыг дан ганц иргэдийн саналд үндэслэх нь учир дутагдалтай байгаа нь харагдаж байна.

2.2. ТЭЗҮ болон төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцооллыг бүрэн хийж чадахгүй байна.

2014 онд аймаг, сумын хэмжээнд ОНХС-ийн санхүүжилтээр 421 ажил төлөвлөж 391 ажил хэрэгжүүлсэн байна.

Аудитын шалгалтаар ажилласан сумууд болон аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх зам, барилга, урсгал засвар болон бусад техник тоног төхөөрөмж нийлүүлэх ажлуудын жагсаалтыг шат шатны ИТХ-аар оруулж батлуулахдаа ТЭЗҮ, зураг төсөв, төсөвт нөлөөлөх байдал, урсгал зардлын тооцооллуудыг хийж бэлэн болгосон ажлуудыг батлаагүй байна.

Хүснэгтээр харуулбал:

Хөвсгөл аймгийн ОНХС-ийн тухайд		
Аймгийн ОНХС-ийн хувьд		
№	Төсөл арга хэмжээний нэр	Зөрчлийн утга
1	Хөл бөмбөгийн талбай	Жагсаалтанд орж батлагдах үед ТЭЗҮ болон зураг төсөв нь хийгдээгүй байсан.
2	Мөрөн суманд 3,3 км урттай хатуу хучилттай авто зам барих ажил	ТЭЗҮ нь оновчтой хийгдээгүйгээс 3,4,7 дугаар багт тавигдсан замуудын урт, өргөнд өөрчлөлт орсон байна.
3	Мөрөн сумын 6,12 дугаар багт засмал зам	
5	Хатгал тосгоны 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга	ТЭЗҮ, зураг төсөв нь бодитой хийгдээгүйгээс төсөвт өртөгт 2 удаа өөрчлөлт орж, 2011-2015 он хүртэл тус барилгын ажил хийгдэж байна.

7	Мөрөн сумын өндөр хүчин чадалтай хяналтын камерын ажил		Гэрээний хугацаа хэтэрч ашиглалтад өгсөн.
Сумын ОНХС-ийн хувьд			
№	Сумдын нэр	Төсөл арга хэмжээ	Зөрчлийн утга
1	Алаг-эрдэнэ	Хэрэгжсэн төсөл арга хэмжээ	ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын ТЭЗҮ болон зураг төсөв, төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй байна.
2	Арбулаг сум	Хэрэгжсэн төсөл арга хэмжээ	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсөв, төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй байна.
3	Баянзүрх	Хэрэгжсэн төсөл арга хэмжээ	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсөв, төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй байна.
4	Бүрэнтогтох	Хэрэгжсэн төсөл арга хэмжээ	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсөв, төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй байна.
5	Галт	Хэрэгжсэн төсөл арга хэмжээ	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсөв хийгдсэн боловч төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй байна.
6	Жаргалант	Хэрэгжсэн төсөл арга хэмжээ	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсөв, төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй байна.
7	Их-Уул	Хэрэгжсэн төсөл арга хэмжээ	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсөв, төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй байна.
8	Мөрөн	Хэрэгжсэн төсөл арга хэмжээ	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсөв хийгдсэн боловч төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй байна.
9	Рашаант	Хэрэгжсэн төсөл арга хэмжээ	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсөв хийгдсэн боловч төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй байна.
10	Рэнчинлхүм бэ	Хэрэгжсэн төсөл арга хэмжээ	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсөв, төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй байна.
11	Тариалан	Хэрэгжсэн төсөл арга хэмжээ	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсөв хийгдсэн боловч төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй байна.
12	Тосонцэнгэл	Дотуур байрны “Халуун ус”	Зураг төсөв нь хангалтгүй, урсгал зардлын тооцоолол хийгдээгүй, одоогийн байдлаар ашиглах боломжгүй
		0,4-ын цахилгаан дамжуулах	2013 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажил, одоогийн байдлаар ашиглаж эхлээгүй, үр ашиггүй хөрөнгө оруулалт

13	Төмөрбулаг	Хэрэгжсэн арга	төсөл	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсөв, төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй байна.
14	Түнэл	Хэрэгжсэн арга	төсөл	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсөв, төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй байна.
15	Улаан-Уул	Хэрэгжсэн арга хэмжээ	төсөл	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсөв, төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй байна.
16	Ханх	Хэрэгжсэн арга хэмжээ	төсөл	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсөв, төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй байна.
17	Хатгал /тосгон/	Хэрэгжсэн арга хэмжээ	төсөл	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсөв, төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй байна.
18	Цагааннуур	Хэрэгжсэн арга хэмжээ	төсөл	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсөв, төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй байна.
19	Цагаан-Уул	Хэрэгжсэн арга	төсөл	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй. 6 төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсөв хийгдээгүй байна.
20	Цагаан-Үүр	Хэрэгжсэн арга	төсөл	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсөв хийгдсэн боловч төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй байна.
21	Цэцэрлэг	Хэрэгжсэн арга	төсөл	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсөв, төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй байна.
22	Чандмань-Өндөр	Хэрэгжсэн арга	төсөл	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсөв, төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй байна.
23	Шинэ-Идэр	Хэрэгжсэн арга хэмжээ	төсөл	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсөв, төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй байна.
24	Эрдэнэбулган	Хэрэгжсэн арга хэмжээ	төсөл	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний ТЭЗҮ болон зураг төсөв, төсөвт нөлөөлөх урсгал зардлын тооцоолол хийгдээгүй байна.

Дээрх хүснэгтээс харахад ихэнх сумдад техник эдийн засгийн үндэслэл нь тодорхойлогдсон, зураг төсөв нь хийгдсэн ажлууд төлөвлөгдөж хэрэгжихгүй байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт заасан *“Зураг төсөвгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын*

төлөвлөгөөнд тусгахыг хориглоно", мөн Төсвийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.2 дахь хэсэгт "Төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана", мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт заасан "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана" гэсэн хуулийн заалтууд болон Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 4.7, 4.9 дэх заалтуудыг тус тус зөрчиж байна.

2.3. Иргэдийн саналаар дэмжигдээгүй нийт 1159,9 сая төгрөгийн өртөгтэй төсөл арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын жагсаалтад оруулж баталсан байна

Тухайн шатны БИНХ-аас эрэмбэлж, тогтоолоор баталгаажуулан ирүүлсэн саналыг үндэслэн шат шатны ЗДТГ-ын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих ажлуудыг тухайн орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан дахин эрэмбэлж, ИТХ-ын хуралдаанд батлуулахаар оруулж байна. Гэвч нийцлийн аудитаар дараах зөрчил илэрч байна. Үүнд:

- БИНХ-аас ирүүлсэн ажлын жагсаалтыг ЗДТГ-ын ажлын хэсэг болон ИТХ- дээр өөрчлөн баталж хөрөнгө зарцуулсан байна.
- ЗДТГ-ын ажлын хэсгийн эрэмбэлж оруулсан ажлуудыг ИТХ-ын түвшинд өөрчилж, иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлуудыг оруулж баталж байна.

Хүснэгтээр харуулбал:

Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй төсөл, арга хэмжээг ИТХ орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батласан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

№	Сумдын нэр	Дүн /сая төг/
1	Алаг-эрдэнэ	34,7
2	Арбулаг	6,0
3	Галт	28,0
4	Рашаант	2,4
5	Тосонцэнгэл	15,9
6	Төмөрбулаг	1,4
7	Улаан-уул	80,7
8	Цагааннуур	64,8
9	Цэцэрлэг	26,0
10	Чандмань-өндөр	30,0
11	Шинэ-идэр	19,0
12	Мөрөн	51,0
13	Аймгийн ОНХС	800,0
14	Нийт дүн	1159,9

Хүснэгтээс харахад нийт 1159,9 сая төгрөгийн төсөл арга хэмжээг иргэдийн саналыг авалгүй төсвийн төлөвлөгөөнд тусгаж Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6⁶ дахь хэсэгт заасан хориглосон заалтыг зөрчсөн байна.

Сумын Засаг дарга МУЗНДНТУТХ-д заасан "Хурлын шийдвэрт хориг тавих"⁷ эрхээ хэрэгжүүлээгүй байна.

⁶ Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ

⁷ МУЗНДНТУТХ-ийн Тухайн Хурал Үндсэн хууль, бусад хууль тогтоомж зөрчсөн, эсхүл өөрийнх нь бүрэн эрхэд үл хамаарах, түүнчлэн хэрэгжих санхүүгийн болон бусад эх үүсвэргүй шийдвэр гаргасан бол Засаг дарга холбогдох шийдвэрт бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эрхтэй.

2.4. **Жагсаалтад орж ИТХ-аар батлуулаагүй 41,7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.**

Аймгийн ОНХС-д 2014 онд улсын төсвөөс 8927,2 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч сумдад 5001,0 сая төгрөг, аймгийн ОНХС-нд 3926,2 сая төгрөгийг олгож үйл ажиллагаа явуулсан байна. 2014 оны жилийн эцсийн зардлын гүйцэтгэлийг харуулбал дараах байдалтай байна.

/мян,төг/

№	Сумын нэр	Санхүүжилтийн дүн	Авсан санхүүжилт			Санхүүжилтийн дутуу
			Улсын төсвийн орлогын шилжүүлэг	Дансны үлдэгдэл давсан орлого	Дүн	
1	Сумдын дүн	8036378,7	5001036,8	307445,7	5308482,6	2727896,2
2	Аймгийн ОНХС	6209272,7	3926180,5	1079769,8	5005950,2	1203322,5
3	Нийт дүн	14245651,5	8927217,3	1387215,5	10314432,8	3931218,6

2014 онд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлсэн ажлуудын гүйцэтгэлийг харуулбал дараах байдалтай байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 10 төсөл арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд нийт хэрэгжилт 86,8% -тай байна.

Шат шатны ИТХ-аар батлуулсан жагсаалтыг үндэслэн ОНХС-ийн зарцуулалтыг хийж байгаа боловч нийцлийн аудитаар тухайн ажлуудын гүйцэтгэлийг хянаж үзэхэд дараах зөрчил дутагдал илэрч байна. **Үүнд:**

100%-ын гүйцэтгэлтэй ажил	363
90%-ийн гүйцэтгэлтэй ажил	6
70%-ийн гүйцэтгэлтэй ажил	12
50%-ийн гүйцэтгэлтэй ажил	7
30%-ийн гүйцэтгэлтэй ажил	7
10%-ийн гүйцэтгэлтэй ажил	18
Төлөвлөсөн боловч хийгдээгүй ажил	20

- Сумын ИТХ-аар батлагдаж, жагсаалтанд ороогүй дараах ажлуудыг санхүүжүүлж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Сумдын нэр	Ажлын нэр	Төсөвт өртөг /сая,төг/	Зарцуулсан хөрөнгө /сая,төг/
Цэцэрлэг	Усны хайгуул, судалгаа хийх	12,0	8,4
Цэцэрлэг	Сумын төвийн байр зүйн зураг хийх	14,0	12,6
Улаан-уул	Шивлэг мунгараг багуудын эмчийн байрны засвар	6,0	6,0
Баянзүрх	Хогын цэгт торон хашаа барих	0,75	0,75
Түнэл	Баяр наадмын талбай завсарлах	9,0	9,0
Нийт		41,75	36,75

- Тосонцэнгэл суманд баригдсан дотуур байрны халуун усны барилгын зураг төсвийг эхнээс нь үндэслэлтэй хийлгээгүйгээс барилга нь баригдсан боловч

цэвэр, бохир ус, халаалтын асуудал нь шийдэгдээгүйгээс ашиглах боломжгүй, үр ашгаа өгч эхлээгүй байна.

- Гүйцэтгэгч аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, санхүүжилтээ олгосон боловч хийж дуусгаагүй дараах ажлууд байна. Үүнд:

№	Сумын нэр	Төсөл арга хэмжээ	Олгосон санхүүжилт
1	Цагаан-үүр	Хогны трактор нийлүүлэх	29,4
2	Жаргалант	Гэрэлтүүлгийн ажил	2,0
3	Улаан-Уул	Мунгараг баг-байцын арын худаг засварлах ажил	7,2
4	Цагааннуур	Ахуйн үйлчилгээний төв	3,2
5	Баянзүрх	Хог хаягдал хадгалах, ариутгах, халдваргүйжүүлэх байр	14,9
	Нийт		56,7

- Гэрээнд заасан хугацаанд ажлаа хийж дуусгаагүй, чанаргүй буюу дутуу хийгдсэн дараах ажлууд байна. Үүнд:

№	Сумдын нэр	Гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн нэр	Тайлбар	Гэрээний дүн
1	Алаг-эрдэнэ	Универсаль трактор	Техникийн нөхцөлөөр тодорхойлсон чанарын шаардлага хангаагүй	60,0
2	Арбулаг	Халуун усны барилга	Гэрээний хугацаа хэтэрсэн	42,7
3	Баянзүрх	Агар хайрханы хамгаалалтын бүс	Гэрээний хугацаа хэтэрсэн	10,0
4	Ренчинлхүмбэ	Сургуулийн урсгал завсар, гадна 00 шинээр барих	Гэрээний хугацаанд ажлаа дуусгаагүй.	10,0
5	Хатгал	Ахмадын өргөө	Гэрээний хугацаанд ажлаа дуусгаагүй.	31,8
6	Аймгийн ОНХС	Шинэ-идэр сумын өвс тэжээлийн фондын бариглын засвар	Зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй	30,0
7	Улаан-уул	Худаг засвар, эмийн байрны засвар	Гэрээний хугацаанд ажлаа бүрэн хийгээгүй	19,0
8	Цагаан-үүр	Хогны машин	Санхүүжилтээ бүрэн авсан боловч, техникийн шаардлага хангасан машин нийлүүлээгүй	29,4
9	Нийт дүн			232,9

- Баяр наадмын зардлыг Засгийн газрын 2010 оны 271 дугаар тогтоолоор Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10,0 сая төгрөг, суманд 5,0 сая төгрөг байхаар тогтоосон заалт, мөн Төсвийн тухай хуулийн 60.3.3 дахь заалтуудыг тус тус зөрчин сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс нийт 26,7 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан байна.

№	Сумдын нэр	Хэтрүүлсэн зарцуулсан дүн /сая төгрөг/
1	Баянзүрх	1,8
2	Тосонцэнгэл	4,9
3	Чандмань-өндөр	15,0
4	Цэцэрлэг	5,0
	Нийт	26,7

- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтын” журамд заасны дагуу захиалагчийн хяналтын зардал болон магадлашгүй ажлын зардлуудыг гэрээнд заасны дагуу суутган тооцож санхүүжилт олгоогүйгээс 27,4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

Аймгийн ОНХС-ийн хувьд:

Аймгийн ИТХ-ын 2013.12.05-ны 7 дугаар хуралдаанаар аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 10 ажлыг 5127,1 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна. Нийцлийн аудитаар дээрх ажлуудын гүйцэтгэлийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

Мөрөн суманд хийгдсэн авто замын ажлуудын талаар: 2014 онд аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр нийт 3145,5 сая төгрөг буюу аймгийн ОНХС-ийн хөрөнгийн 50,7%-ийг зарцуулсан Мөрөн сум доторх хатуу хучилттай авто зам барих, үерийн далан байгуулах ажлыг хийсэн байна. Үүнд:

№	Ажлын нэр	Төсөвт өртөг /сая,төг/	Хэрэгжилтийн хувь
1	Мөрөн сум доторх 3,3 км хатуу хучилттай авто зам барих /3.4.7.8/	2045,5	100
2	Мөрөн сум доторх 0,9 км хатуу хучилттай авто зам барих /6.12/	450,0	80
3	Мөрөн сум үерийн далан барих	650,0	100
4	Нийт	3145,5	

Аймгийн Аудитын газраас хийсэн “Авто замын хөрөнгө оруулалт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын хүрээнд дээрх замын ажлуудын худалдан авах ажиллагаа, гүйцэтгэлийн байдалд аудит хийсэн ба худалдан авах ажиллагааг журмын дагуу явуулсан гэж үзсэн байна. Гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчлүүдийг илрүүлсэн байна. Үүнд:

- ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдэх ажлуудын жагсаалтыг аймгийн ИТХ-ын хуралдаанаар батлуулахдаа авто замын ажлуудын магадлангаар ороогүй зураг төсвийг үндэслэн төсөвт өртгийг батлуулснаас замын урт, өргөнийг хасах өөрчлөлтийг гүйцэтгэлийн явцад хийж төсөвт өртөгт багтаасан байна. /Гэхдээ зохиогчийн зөвшөөрлөөр зураг төсөвт өөрчлөлт оруулсан байна./
- Мөрөн “Зүүн 4 зам”-ын уулзвар буюу 6,12 дугаар багийн нутаг дэвсгэрт барьсан зам, 7 дугаар багийн замын уулзвар зөрсөн байна. Энэ нь Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийн “замууд нэг түвшинд огтлолцсон бэлчир буюу зорчих хэсгийн захын дугуйрч байгаа эхлэлийг түүний эсрэг тал уруу шулуун холбож хязгаарлахад үүссэн талбайг уулзвар гэнэ” гэсэн заалтад нийцэхгүй байна. Дээрх

зөрчилтэй холбогдуулан аймгийн Засаг дарга болон аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга нарт шаардлагатай зөвлөмжүүдийг хүргүүлсэн байна.

Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу дараах ажлуудыг хийсэн байна.

1. Мөрөн зүүн 4 замын уулзварт авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг аюулгүй байдлаар зохицуулахын тулд гэрлэн дохио байрлуулсан ба цаашид уулзварыг тэгшлэх талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллах талаар аймгийн ИТХ-аас аймгийн ЗДТГ-ын ХБХ-т үүрэг даалгавар өгч ажилласан байна.
2. 2015 оны хөрөнгө оруулалтын ажлуудын зураг төсвийг магадлангаар оруулан, баталгаажуулсны дараа ажлын жагсаалтанд оруулахад анхаарч ажиллаж байна.

Хөл бөмбөгийн талбай барьж байгуулах ажлын талаар: Мөрөн суманд Хөл бөмбөгийн талбай барих ажлыг гүйцэтгүүлэхээр “Дэрэннаран” ХХК-тай гэрээ байгуулан ажилласан байна. Уг ажлын гэрээний дүн нь 798,4 сая төгрөг, хугацаа нь 2014.07.28-2014.09.15-нд дуусгах гэрээ байгуулсан боловч одоогийн байдлаар ажлын гүйцэтгэл нь 80%-тай байна. Зураг төсөвт заагдсан гүйлтийн замын ажил дутуу, энэ талаар *тодруулахад*: гүйцэтгэгч компаниас төслийн менежерийн багт албан бичгээр хүсэлт ирүүлсний дагуу гэрээний хугацааг 2015.06.25 хүртэл сунгасан байна. Гэрээ сунгасны шалтгаан нь:

- Хөл бөмбөгийн талбайн материалыг Чехасловск улсаас худалдан авч, Польш улсын тээврийн компанитай гэрээ байгуулан дамжуулан тээвэрлэх болсон нь нилээд хугацаа алдсан⁸ болно.
- Гүйлтийн замын ажил нь гадна агаарын температур +10-аас дээш хийгдэх технолгийн горимтой юм байна.

Дээрх шалтгааны улмаас аймгийн Засаг даргын 2014.05.05-ны өдрийн А/180 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2014.12.03-ны өдөр хөл бөмбөгийн талбайн ажлын гүйцэтгэлд хяналт хийж, тулгамдаад байгаа асуудлуудыг шийдвэрлэн гэрээний хугацаанд өөрчлөлт оруулсан байна. Нийцлийн аудитаар дээрх ажлыг аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтанд ИТХ-д оруулж хэлэлцүүлэх үед нэмж оруулж баталсан боловч энэ нь ард иргэдийн нийтлэг эрх ашигт нийцсэн, аймаг орон нутагт тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн гэж үзэхгүй байна.

Мөрөн сумын ЗДТГ-ын барилгын талаар: Уг ажил нь 2013 оны аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр эхэлсэн ба 2014 онд 450,0 сая төгрөгийн хөрөнгө баталж, барилгын ажлыг дуусган, 2014.09.05-нд улсын комисс ажиллан ББАК-05 акт үйлдэж ашиглалтанд хүлээж авсан байна.

Хатгал тосгоны 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга: Тус хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил нь 2011 онд эхэлсэн ба төсөвт өртөгт нь 2 удаа

⁸ Өмнө нь Украин улсаар дамжуулан тээвэрлэдэг байсан нь давтагдашгүй хүчин зүйлийн улмаас хүчингүй болсон.

өөрчлөлт орж 1284,2 сая төгрөг болж батлагдсан талаар өмнөх нийцлийн аудит болон санхүүгийн аудитаар холбогдох зөвлөмжийг өгч байсан болно. 2014 онд тус ажилд 345,0 сая төгрөг батлагдсан байна. Уг ажлыг 2015 онд дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.

Шинэ-идэр сумын өвс тэжээлийн фондын барилгын засвар: 2014 оны аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөвт өртөг нь 30,0 сая төгрөг, гүйцэтгэгч нь "Илч түгээгч" ХХК байна. Нийцлийн аудитаар тус барилгын ажлын гүйцэтгэлийг зураг төсөвтэй тулган шалгахад зургийн дагуу хийж гүйцэтгээгүй, дутуу хийсэн байна.

2.5. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулсан байна.

Аймгийн хэмжээгээр 2014 онд ОНХС-ийн хөрөнгөөр нийт 421 төсөл арга хэмжээг санхүүжүүлэн үйл ажиллагаа явуулсан байна. Нийцлийн аудитын хүрээнд ажилласан бүх сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээнд ТБОНӨХБАУХАТХ-ийн холбогдох заалтуудын дагуу 10,0 сая төгрөгнөөс дээш үнийн дүнтэй төсөл арга хэмжээнд харьцуулалт, нээлттэй тендер шалгаруулалтын аргыг сонгон, 10,0 саяаас доош үнийн дүнтэй төсөл арга хэмжээнд шууд гэрээ байгуулах замаар худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулсан байна. Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны аргуудыг оновчтой сонгож ажилласан байна. Хавсралт№-02

Худалдан авах ажиллагаанд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

- Худалдан авах үйл ажиллагаанд нэг үнэлгээний хороо байгуулж ажилласан. Тухайлбал: Тосонцэнгэл сум, Түнэл сум
- "ОНХС-ийн заавар"-аар зөвшөөрсөн⁹ нарийн мэргэжил шаардагдахгүй, энгийн ажлыг Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаа зохион байгуулж, ажилгүй иргэдийг түр ажлын байраар ханган ажиллах үйл ажиллагаанд анхаарал хандуулаагүй
- ТБОНӨХБАУ худалдан авах тухай хуулийн 34.1.3 дахь заалтыг зөрчсөн. **Тухайлбал:** Жаргалант сум - 20000,0 мянган төгрөг
- Мөрөн сум нь "Хүндэтгэл бахархалын хаалга" төсөл арга хэмжээний хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа худалдан авах ажиллагааны журам зөрчиж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. Тодруулбал, Мөрөн сумын "Хүндэтгэл бахархалын хаалга барих" ажлын гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороо 2014 оны 6 дугаар сарын 17-нд Мөнх-Өргөө ХХК, Их-Цэц брэнд ХХК, Идэр нумт ХХК-д тендерийн урилга хүргүүлсэн бөгөөд дээрх компаниудаас Мөнх-Өргөө ХХК, Идэр нумт ХХК тухайн худалдан авах ажиллагаанд оролцох боломжгүй тухайгаа албан

⁹ Сангийн сайдын 2014 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 43 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 8.2, 8.3 дахь хэсэг

бичгээр хариу өгсөн байдаг. Харин "Их Цэц брэнд" ХХК тендерийн материалаа ирүүлсэн бөгөөд тухайн компаний ирүүлсэн 51,005,966 төгрөгийн санал бүхий тендерийн материалыг үнэлгээний хороо хянаж, улмаар гүйцэтгэгчээр сонгон шалгаруулж шийдвэрлэсэн болох нь үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлээр нотлогдож байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 33 дугаар зүйлийн 33.1¹⁰, 33.2¹¹ дахь хэсэгт заасан "харьцуулалтын арга"-ын журмыг үнэлгээний хороо баримтлалгүй гүйцэтгэгчийг "шууд гэрээ байгуулах" журмаар сонгон шалгаруулсан зөрчил илэрч байна.

Мөн үнэлгээний хороог "А" сертификаттай хүмүүсээр бүрдүүлэн томилж байгаа боловч үнэлгээний хороо нь үнэлгээг бодитой хийж чадаагүй байна. **Тухайлбал:** Төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийн тендерийг санхүүгийн, боловсон хүчний, техник технологийн хувьд хир зэрэг байгаа талаар үнэлгээ хийхгүй байна. Энэ байдлаас болоод хийсэн ажлууд нь хангалтгүй, гэрээнд заасан хугацаандаа ажлаа хийж гүйцэтгээгүй гэх мэт зөрчил дутагдлууд гарсаар байна.

2014 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн нийт төсөл арга хэмжээний гэрээний үнийн дүнгийн ангилал дараах байдалтай байна.

Гэрээний үнийн дүн /сая төгрөг/	Нийт тоо хэмжээ	Хувь
0-5,0	128	28,9
5,1-15,0	152	34,3
15,1-25,0	77	17,3
25,1-35,0	29	6,5
35,1-45,0	17	3,5
45,1-55,0	7	1,6
55,1-65,0	3	0,7
65,1-75,0	6	1,3
75,1-85,0	2	0,4
85,1-95,0	3	0,7
95,1-200,0	5	1,2
201-дээш	2	0,4
Нийт ажил	421	100

Хүснэгтээс харахад 0-5,0 сая хүртлэх болон 5,1-15,0 сая төгрөгийн үнийн дүнтэй ажлуудыг нийт ажлын 63,2 хувьд төлөвлөж гүйцэтгэсэн байна. Энэ нь худалдан авах ажиллагааг шууд гэрээ байгуулах замаар зохион байгуулж явуулах сонирхол их байгааг харуулж байна.

2.6. ОНХС-ийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт бодит байдалтай нийцэхгүй байна.

ОНХС-ийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан маягт, аргачлалын дагуу гаргасан байна. Сумдын ОНХС-ийн тайланг

¹⁰ Техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх

¹¹ Техникийн болон бусад шаардлагыг хангаж байгаа хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид энэ хуулийн 29.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох

тусад нь гаргаж, сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланг гаргахдаа мөнгөн сууриар гаргасан ба ОНХС-ийн үйл ажиллагаатай холбоотой ямар ч авлага, өглөг тусгаагүй байна. Энэ нь 2014 оны ОНХС-ийн журмын 10.5 *"аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ОНХС-ийн санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гарган....."* гэсэн заалттай нийцэхгүй байна. Тухайлбал: Бүртгэл, тайланд тусгаагүй өр авлагатай холбоотой нийт 2,4 тэрбум төгрөгийн зөрчил илэрч байна. Хавсралт №-01

2014 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдээд холбогдох байгууллагууд дээрээ бүртгэлд тайланд тусгасан боловч өмчлөлийн асуудал шийдэгдээгүй буюу төрийн өмчийн хөрөнгө дээр орон нутгийн өмчөөр хөрөнгө оруулалт хийгдээд хаана ямар байгууллага дээр орлого авах нь шийдэгдээгүй 413,4 сая төгрөгийн хөрөнгийн асуудал байна.

Хүснэгтээр харуулбал:

№	Сумын нэр	Гэрээний дүн /сая,төг/	Ажлын гүйцэтгэл	Гүйцэтгэгч
1	Тариалан	40,0	100	"Дийплек" ХХК
2	рашаант	16.4	100	"ЖЕММ" ХХК
3	Баянзүрх	52.9	100	"Алтан бэрс интернэшнэл" ХХК
4	Их-уул	68.6	100	"Да хот" ХХК ХХК
5	Ханх	98.3	100	"Алтан бэрс интернэшнэл" ХХК
6	Хатгал	33.9	100	"Мөнгөн нуур" ХХК
7	Цагааннуур	34.8	100	"Нэмэх хасах" ХХК
8	Цэцэрлэг	27.9	100	"Хөвсгөл мөнгөн" ХХК
9	Чандмань-өндөр	40.6	100	ИБЧ ХХК
10	Нийт	413.4		

Энэ нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан *"ОНХС-ийн заавар"-ын 4.5 "орон нутгийн төсвийн бус байгууллагуудад ОНХС-аас хөрөнгө зарцуулахгүй байх"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Тухайлбал: Сумдад 0,4 шугамын өргөтгөлийн ажлууд хийгдсэн ба эдгээр нь Эрдэнэтийн ЦДШ, Булганы ЦДШ, Оросын холбооны улсын ЦДШ дээр өргөтгөл нь хийгдсэн байна. Одоогийн байдлаар сумдын ЗДТГ-ын нягтлан бодох бүртгэлд тусгасан байгаа боловч ЗДТГ-ын зүгээс тухайн хөрөнгийн ашиглалт хамгаалалт, урсгал засварын асуудлуудыг хариуцан ажиллах боломжгүй байгаа ба өмчлөлийн асуудал ч маргаантай байна.

ОНХС-ийн санхүүгийн үйл ажиллагаанд нэгдүгээр гарын үсгийг Засаг дарга, хоёрдугаар гарын үсгийг зарим сумдад ЗДТГ-ын нягтлан бодогч, төрийн сангийн төлөөлөгч гэх мэт албан тушаалтнууд харилцан адилгүй зурж байна. Мөн ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалтанд ашиглаж байгаа программ хангамжийг сумдын төрийн сангийн төлөөлөгч нар, аймагт аймгийн төсвийн ерөнхий санхүүч хариуцан холбогдох мэдээллийг оруулж байна. Энэ байдлаас харахад санхүүгийн үйл ажиллагаанд гарын үсэг зурж байгаа албан тушаалтан,

ОНХС-ийн программ хангамжийг ашиглаж байгаа албан тушаалтныг нэг болгож мэдээллийг нэг сувгаар гаргадаг болговол нягтлан бодох бүртгэл, тайлагналын асуудал бодитой гарах, цаашид бүртгэл, тайлагналаар тавих хяналт сайжрах боломж байна.

ОНХС-ийн хөрөнгийн санхүүгийн анхан шатны баримт материал хангалтгүй байгаа нь нийцлийн аудитаар ажиглагдаж байна. Нийцлийн аудитаар ажилласан сумдад анхан шатны баримт бүрдүүлэлтэнд анхаарч, дутуу баримтуудыг нөхөж бүрдүүлж биелэлтийг аймгийн Аудитын газарт ирүүлэх зөвлөмжийг хүргүүлж ажилласан.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн гүйцэтгэлээс төсөвт тусгагдсан магадлашгүй ажлын зардал, техник хяналтын зардлыг суутган тооцохгүйгээр шууд санхүүжилтыг олгож байгаа зөрчил илэрч байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан "төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтын журам"-ын 3.13, 3.19-д заасан заалтуудтай нийцэхгүй байгаагаас нийцлийн аудитаар 27,3 сая төгрөгийн төлбөрийн акт тавигдсан болно.


БҮЛЭГ 3

- ОНХС-ийн гүйцэтгэлд тавих хяналт, үнэлгээ хангалтгүй байна.

3.1. ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжилтийг иргэдэд ил тод нээлттэй мэдээлж байна.

Нийцлийн аудитын хүрээнд сумдад ажиллахад ОНХС-ийн зарцуулалтын талаарх мэдээллийг сумын ЗДТГ-ын ил тод байдлын самбарт тавьж иргэдэд танилцуулахын зэрэгцээ сумын ИТХ-аар энэ талаарх мэдээллийг иргэдэд өгч байгаа тухай ажлын тайлангуудад тусгагдсан байна. Түүнчлэн сумын ИТХ, Засаг даргаас ажлын хэсэг томилуулан ажиллаж ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн чанар байдалд хяналт тавьж, иргэдэд танилцуулж байгаа нь тухайн ажлын ил тод байдлыг илтгэж байна.

Нийцлийн аудитын хүрээнд явуулсан санал асуулгын **"Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтын ямар төсөл арга хэмжээ Танай хороо,сум, дүүрэгт хэрэгжиж буй талаар та хэр мэдээлэлтэй байна вэ?"** гэсэн асуултанд иргэд дараах байдалтай хариулж байна.



ОНХС-ийн төлөвлөгөө гүйцэтгэлийн талаар ил тод мэдээлэх ажлыг сум орон нутагт хангалттай ажил зохион байгуулсан ба иргэд хүсвэл мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн байна. Тухайлбал: *Бүх сум интернэтийн сүлжээтэй болсон ба онлайнаар мэдээлэл авах боломж бүрдсэн гэж үзэж байна.* Энэ байдал нь санал асуулгын дүнгээр ч нотлогдож байна. Санал асуулгад оролцсон иргэдийн 52% нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих ажлын жагсаалтын талаар тодорхой мэдээлэлтэй байдаг гэсэн хариулт өгч байна.

3.2. Захиалагчийн хяналт тавих ажлын хэсэг томилсон боловч хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн инженерийн хийцтэй зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн байдалд ГХБХБГ, Мэргэжлийн хяналтын газар зэрэг мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн инженерийн хийцтэй барилга байгууламжийн гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагын оролцоогүйгээр сумын Засаг даргын томилсон ажлын хэсэг захиалагчийн хяналт тавьж ажилласан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтын тухайд аймгийн орон нутгийн хөгжлийн сан, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтэд хяналт тавьсан байдлыг тус тусад нь авч үзлээ.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн тухайд:

Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтын журам"-ын 3.1, 4.2, 4.4 дэх заалтууд, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2013 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хэсгийн "б" заалтуудыг үндэслэн "гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээ дүгнэх үүрэг бүхий төслийн менежер, түүний багийг

захиалагчийн шийдвэрээр байгуулах"¹² заалтын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар аймгийн ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр 10 төсөл, арга хэмжээг баталсан. Үүнээс баяр наадмын зардал, зураг төсвийн зардлаас бусад бусад 5 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн байдалд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

Үүнийг хүснэгтээр харуулбал:

№	Төсөл арга хэмжээний нэр	Төслийн менежер, гишүүд	Нарийн бичгийн дарга	Ажлын хэсгийн тэмдэглэл, тайлан
1	Хатгал тосгоны 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил	Ж.Ганболд /Менежер/ – аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга, гишүүдэд Ж.Ганзоригт, Д.Мягмарсүрэн, П.Даваадалай	Б.Энхжаргал-ГХБХБГ-ын мэргэжилтэн	Төслийн менежерийн баг 2014 онд 2 удаа явцын хяналт тавьсан гэх тайлбарыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга өгсөн ч хяналт тавьсан тухай баримт хянуулаагүй.
2	Шинэ-Идэр сумын 2 дугаар багийн төв рүү ЦДАШ, дэд станц барих ажил	Д.Отгонбаяр /Менежер/- "Хөвсгөл Эрчим Хүч" ХХК-ийн ерөнхий инженер, гишүүдэд Д.Нямбаяр, Б.Болд	Б.Энхжаргал-ГХБХБГ-ын мэргэжилтэн	Төслийн менежерийн баг ажиллаагүй.
3	Мөрөн суманд "Үерийн далан барих ажил"	Г.Гандэлгэр /Менежер/- аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн дарга, гишүүдэд Д.Цолмон, Ч.Төгсбат, Д.Мягмарсүрэн	Э.Аззаяа-Аймгийн ЗДТГ-ын ХБХ-ийн мэргэжилтэн	Төслийн менежерийн баг ажилласан тухай баримт хянуулаагүй.
4	Мөрөн сумын ЗДТГ-ын барилгын ажил	Ц.Гансүх /Менежер/- Мөрөн сумын Засаг дарга, гишүүдэд Б.Оюун, Д.Мягмарсүрэн, А.Цэрэндулам	С.Уранцэцэг-ГХБХГ-ын мэргэжилтэн	2014.09.05 ББАК/05 дугаартай актаар тухайн барилгыг зураг төсвийн дагуу хийгдсэн гэж хүлээж авсан
5	Мөрөн суманд Хөлбөмбөгийн талбай байгуулах ажил	Ц.Гансүх /Менежер/- Мөрөн сумын Засаг дарга, гишүүдэд Ц.Баярсайхан, Б.Цэрэн-Очир, Д.Мягмарсүрэн	С.Уранцэцэг-ГХБХГ-ын мэргэжилтэн	2014.12.03-нд төслийн менежерийн баг явцын хяналт тавьсан.

Аймгийн ОНХС-ын санхүүжилтээр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн байдлыг аудитын явцад зураг, төсөвтэй нь тулгаж шалгахад дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

¹² Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 6 сарын 7-ны өдрийн 43 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журам"-ын 3.19 дэх хэсэгт

1. **Мөрөн сумын ЗДТГ-ын конторын барилгын тухайд:** Агааржуулалтын систем ажилладаггүй, цонх, ханын завсрын дулаалга муу хийгдсэнээс цанталт өгсөн, өнгө будаг, обой, хана таазны будаг ховхорсон, булангуудаар цанталт өгч мөөнгөнцөр үүссэн, цонх нь 3 давхар шилтэй вакум цонх байхаар төлөвлөгдсөн ч ердийн дан шилтэй вакум цонх угсарсан байна.
2. **Хатгал тосгоны 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын тухайд:** Гадна ханын дулаалгад 15 см зузаантай хөөсөнцөр дулаалга хийхээр төлөвлөгдсөн ч 10 см зузаантай хөөсөнцөр хийсэн, шалны дулаалгад 15 см хөөсөнцөр хийхээр төлөвлөгдсөн ч 10 см болгож өөрчилсөн, цонх болон хананы завсар зайгүй угсрагдсан учир дулаалга чигжээс хийх боломжгүй болсон.
3. **Шинэ-Идэр суман дахь сум дундын өвс тэжээлийн фондны барилгын засварын тухайд:** Тухайн байгууламж зураг төсвийн дагуу хийгдээгүй, зурагт төлөвлөснөөр хуучин тэжээлийн фондны барилгыг засварлахаар төлөвлөгдсөн байтал тусад нь саравч хийсэн нь одоогоор ашиглах боломжгүй, энэ жил ашиглаагүй. Учир нь ил задгай, харуул хамгаалалтгүй.
4. **Цагааннуур сумын халуун усны барилгын тухайд:** Ашиглалтын шаардлага хангахгүй, цооногийн багтаамж бага учраас дүүрсэн, барилгын дээвэр бүрэн хийгдээгүй байна.
5. **Цагааннуур сумын Хормой багийн төвийн барилгын ажлын тухайд:** Ашиглалтын шаардлага хангахгүй, зураг төсвийн дагуу хийгдээгүй байхад ашиглалтанд хүлээн авсан байна.
6. **Төмөрбулаг сумын спорт заалны засварын ажлын тухайд:** Тус барилгын доторлогоог зураг төсөвт зааснаар ОСВ хавтангаар доторлоогүй байна.

Дээрх зөрчлүүдийн гол шалтгаан захиалагч төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явцад болон хүлээж авахдаа зураг, төсөвтэй нь тулгаж хяналтыг хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой байна.

2013 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн дараах ажлууд гэрээнд заасан хугацаандаа ашиглалтанд ороогүй байна.

1. Мөрөн сумын нэгдсэн эмнэлгийн хог хаягдлын байгууламжийн барилгын ажил /2013 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажил: Тус ажлын гүйцэтгэгч нь "Агар-Эрдэнэс" ХХК, гэрээнд тусгагдсан санхүүжилтээ 100% авсан боловч ажлаа бүрэн дуусгаагүй байсныг аудитын хугацаанд гүйцэтгүүлсэн болно.

2. Түнэл сумын хогны машины тухайд: Ашиглалтанд хүлээж авахдаа гаалийн бичиггүй техник хүлээн авснаас өнөөдрийг хүртэл улсын дугаар авч чадаагүй, ашиглах боломжгүй болсон байна.

3. Цагаан нуур сумын цэцэрлэгт хүрээлэн чанар муу хийгдсэн, хашааг дахин засварлах шаардлагатай байна.

Дээрх зөрчил дутагдлаас дүгнэхэд Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хяналт хангалтгүй, хяналт хийхээр очсон ч зураг төсөвтэй тулган шалгаж үе шатны хяналтыг хангалттай сайн хийж

чадахгүй байгаа нь нотлогдож байна. Иймд гүйцэтгэлд хяналт хийж байгаа төрийн албан хаагчид болон ажлын хэсэгт орж ажиллаж байгаа ажилтнуудад хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж байна.

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн тухайд:

Төсвийн тухай хуульд заасан, төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах "төсвийн шууд захирагч"-ийн эрх, үүргийн дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсгийг сумын Засаг даргын захирамжаар томилон ажиллуулсан байна. Гэвч төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавьсан тухайн ажлын хэсгийн тэмдэглэл, дүгнэлт, зөрчлийн дагуу авсан арга хэмжээтэй холбоотой баримт сумдад хангалтгүй байна.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан төсөл, арга хэмжээний төсөвт тусгасан захиалагчийн хяналтын зардлыг суутгалгүй 100 хувь гүйцэтгэгч компанид олгосон, захиалагчийн хяналт хийхтэй холбоотой зардлыг сумын ЗДТГ-ын төсвөөс болон сумын ИТХ-ын төлөвлөгөөнд тусад нь тусган батлуулж зарцуулсан зэрэг зөрчлүүд илэрч байна.

Түүнчлэн төсөл, арга хэмжээний төсөвт тусгагдсан магадлашгүй ажлын зардлыг "акт"¹³ үндэслэж гүйцэтгэгчид олгох журмыг зөрчиж олгосон байна. Төсөл, арга хэмжээний төсөвт тусгасан захиалагчийн хяналтын зардал, магадлашгүй ажлын зардлыг зориулалтын дагуу зарцуулалгүй, "акт"-аар баталгаажаагүй гүйцэтгэлд санхүүжилт олгосон сумдыг хүснэгтээр харуулбал:

№	Сумын нэр	Захиалагчийн хяналтын зардал, магадлашгүй ажлын зардлын дүн /сая,төг/
1	Арбулаг	0,4
2	Баянзүрх	1,9
3	Ренчинлхүмбэ	6,2
4	Түнэл	1,1
5	Ханх	6,3
6	Цагааннуур	0,2
7	Цагаан-үүр	5,3
8	Чандмань-өндөр	0,9
9	Эрдэнэбулган	2,4
10	Хатгал	2,5
	Нийт	27,2

Аудитын явцад эдгээр зөрчилтэй холбогдуулан төлбөрийн акт, албан шаардлага тогтоож, хяналтын зардал, магадлашгүй ажлын талаарх хууль, журамд заасан заалтуудыг хэрэгжүүлэх талаарх зөвлөмжийг өгч ажиллалаа.

Суманд захиалагчийн хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой мэргэжлийн байгууллагын оролцоо, зөвлөмж зайлшгүй шаардлагатай байгаа нь сумдад хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний зураг, төсвийг тулгаж хяналт тавьж чадахгүй байгаа, төсвөөс нь захиалагчийн хяналтын зардлыг суутган авч хяналт тавихдаа ашиглахгүй байгаа зэрэг наад захын жишээнээс харагдаж байна.

3.3. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэн, иргэний

¹³ Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам"-ын 3.13 дахь хэсэгт заасан

нийгмийн байгууллагууд хамтран хяналт тавьж, үнэлгээ хийж нийтэд ил тод мэдээлэхгүй байна.

Төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг хүлээн авахтай холбогдуулан захиалагч талаас журам зааврын дагуу хяналт тавих ажлын хэсэг, ашиглалтанд хүлээж авах комисс томилсон боловч, гүйцэтгэлд тавих хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй, ажлыг хүлээж авсан боловч гүйцэтгэл дутуу ажлыг бүрэн гүйцэтгэсэн мэтээр баримт бүрдүүлэн хүлээн авсан байна.

Тухайлбал: Баянзүрх сумын эрүүл мэндийн төвийн “Хог хаягдлын ариутгалын автоклав, дагалдах тоног төхөөрөмжийн хамт авах” арга хэмжээний хүрээнд гүйцэтгэгчээс 14,9 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээ хүлээн авсан гэж комиссын акт үйлдэж хүлээн авсан боловч гүйцэтгэгч “Эмт хөгжил” хоршоо 1,9 сая төгрөгийн өртөг бүхий эд хөрөнгийг ашиглагч талд хүлээлгэж өгөөгүй байна. Энэ зөрчилтэй холбогдуулан “Эмт хөгжил” хоршооноос 1,9 сая төгрөгийн өртөг бүхий эд хөрөнгийг гаргуулж ашиглагчид 2015 оны 6 дугаар сарын 15-ны дотор хүлээлгэн өгөх албан шаардлагыг тус сумын Засаг даргад хүргүүлж ажиллаа.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг захиалагч хууль, журмын дагуу хүлээж авсан эсэхэд сумын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хамтран хяналт тавьж, үнэлгээ өгөхөөр журамлагдсан байна¹⁴.

Сангийн сайдын 2014 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” -т “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана”¹⁵ гэж заасан.

Түүнчлэн “тухайн шатны ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо нь сайн дурын идэвхитэн иргэд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ОНХС-гаас хэрэгжсэн хөтөлбөр төсөл арга хэмжээний үр дүнд хяналт тавьж, үнэлгээ хийнэ” гэж ИТХ-ын дэргэдэх Хяналтын хорооны эрх, үүргийг нарийвчлан зохицуулсан байна.

Аудитын явцад энэхүү заалтын дагуу Рэнчинлхүмбэ, Баянзүрх, Цагааннуур, Улаан-Уул, Бүрэнтогтох, Төмөрбулаг сумын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо хяналт тавьсан бөгөөд бусад сумдын хувьд “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-т заасан хяналтын хороо ч байгуулагдаагүй “заавар”-ын хэрэгжилт хангалтгүй байна.

ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо хяналт тавьсан боловч иргэд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаагүй байна.

¹⁴ Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-т

¹⁵ Сангийн сайдын 2014.3.6-ны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1 дэх хэсэг

3.4. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн 82,8%-ийг хэрэгжүүлж ажилласан байна.

2013 оны ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтанд хийсэн нийцлийн аудитаар нийт 17 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлж ажилласан байна. Аймгийн ИТХ, Санхүү төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлогын хэлтэс, Худалдан авах ажиллагааны албанаас зөвлөмжийг биелэлтийг ирүүлэн ажилласан. Харин сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хүргүүлээгүй тул сумдад ажиллах хугацаанд өмнөх зөвлөмжийн биелэлтийг тооцох боломжгүй байсан болно.

Өмнөх зөвлөмжийн биелэлтийг үнэлсэн байдал /ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын байдалд хийсэн нийцлийн аудитын зөвлөмж/

№	Хүргүүлсэн зөвлөмж	Биелэлт	Аудитаар үнэлсэн
Аймгийн ИТХ-ын дарга Т.Болдбаатарт			
1	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажил, төсөл арга хэмжээний жагсаалтыг АИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж байх.	2014 он, 2015 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтыг аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн баталуулж байна.	Тооцов. /100%/
2	ОНХС-ийн гүйцэтгэлийн үр дүнгийн тайланг хэлэлцэж, ОНХС болон бусад төсөл хөтөлбөрөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн эзэмшил, ашиглалтанд хяналт тавьж ажиллах.	2014 оны ОНХС-ийн гүйцэтгэлийг 2015.03.11-ны өдрийн аймгийн ИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлсэн байна.	Тооцов. /100%/
3	ОНХСангийн төслөөр хийгдсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, машин механизмийн бүртгэл, эзэмшилт, ашиглалтын талаар бодлого боловсруулж шийдвэрлүүлэх.	Журам боловсруулаагүй байна.	0
АЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Х.Ган-очирт			
4	Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх ажил, хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхөд Төсвийн тухай хууль болон холбогдох эрхийн актуудыг мөрдөж ажиллах	Холбогдох хууль эрх зүй, журам заавруудаар	Тооцов. /100%/
5	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг сумын ИТХ-аар хэлэлцэж дүгнэлт гаргаж байх	ОНХС-ийн тухайн оны ажлын тайланг ИТХ—д тайлагнаж байна.	Тооцов./100%/
6	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим ажил, хөтөлбөр арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг бэлтгэж хүргүүлэх, олон нийтээс хамгийн их санал авсан ажил, хөтөлбөр, төсөл арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг эрэмбэлэн, иргэд, олон нийтэд танилцуулж үр ашигтай, иргэдийн хэлэлцүүлгээр дэмжигдсэн арга хэмжээг төлөвлөж байх.	23 сум 1 тосгоны 4000 гаруй хүн биечлэн санал өгч, 600 гаруй хүн цахим хэлбэрээр санал өгсөн.	Хангалтгүй /баримтаар нотлогдохгүй байна. / 60% /
7	Сумын ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлын санхүүжилт үйл ажиллагаанд хяналт тавьж хүндрэл учруулдаг явдлыг зогсоох.	Хяналт тавигдаагүй болно.	Тооцов. /100%/

8	ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтыг төсөл арга, хэмжээ бүрээр нэгтгэсэн судалгаа гаргаж аль, аль чиглэл рүү түлхүү зарцуулагдаж байгааг аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан түүний үр дүнд шинжилгээ хийж байх.	Шинжилгээ хийсэн байна.	Тооцов. /100%/
АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Г.Сувдад			
9	Орлогын шилжүүлгээс сумдад олгох шилжүүлгийг журамд заасан зарчмуудын дагуу тооцож байх	Хангалттай биелсэн	Тооцов. /100%/
10	Сумдын ОНХСанд олгох шилжүүлгийг сар улирлын хуваарийн дагуу олгож байх	Биелэх боломжгүй нөхцөл байдал үүссэн талаар тайлбар ирүүлсэн байна.	Бүрэн биелээгүй
Аймгийн ХААА-ны дарга Б.Болдод			
11	Зөвлөх сонгох үйлчилгээний төсөвт өртөгт магадлашгүй ажлын зардлыг тооцож байгааг таслан зогсоох.	Зөвлөмжийн хэрэгжилтийг албан тоотоор ирүүлсэн.	Тооцов /100%/
12	Үнэлгээний хорооны гишүүдийг мэргэшүүлэх.	2 удаа сургалт зохион байгуулж журам зааваруудаар мэдээлэл өгсөн.	Тооцов. /100%/
13	Сумдын Үнэлгээний хорооны боловсруулсан тендерийн баримт бичгийн үнийг аймгийн ХААА-ны дансанд төвлөрүүлдэг явдлыг таслан зогсоох	Энэ зөрчлийг бүрэн арилгасан байна.	Тооцов. /100%/
14	Сумдад зохион байгуулагдаж байгаа худалдан авах ажиллагаанд оролцож хүндрэл учруулдаг явдлыг зогсоох	Бүрэн зогсоосон байна.	Тооцов. /100%/
15	Нийт		82,8%

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтээс харахад аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын жагсаалтыг гарахын тулд иргэдээс санал авах, эрэмбэлэх, сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг сар улирлын хуваарийн дагуу олгох, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудыг бүртгэл тайланд тусгах, ОНХСангийн төслөөр хийгдсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, машин механизмийн бүртгэл, эзэмшилт, ашиглалтын талаар бодлого боловсруулж шийдвэрлүүлэх зэрэг зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.

3.5. Төрийн байгууллагууд Шилэн дансны мэдээллийг Засгийн газрын 2014 оны 384 тоот тогтоолоор баталсан “Журам”-д заасан агуулга, нийтлэг стандартад нийцүүлэн тавьж хэвшээгүй байна.

Нийцлийн аудитаар ажилласан сумдын төсөвт байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтууд, Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн данс цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу шаардлагатай мэдээллүүдийг shilendans.gov.mn сайтад байршуулсан эсэх талаарх хэрэгжилтийг хянаж үзэв. Мэдээллийг ил тод байршуулахад бүх төсөвт байгууллагуудын удирдлагууд анхаарал хандуулан ажиллаж байгаа боловч дараах зөрчил дутагдал илэрч байна.


- Төсөвт байгууллагууд батлагдсан төсөв болон сарын мэдээгээ Шилэн дансны тухай хуулийн 6.1.2-т заасны дагуу нэгдсэн сайтад мэдээллээгүй.
- Худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг “Журам”-д заасан агуулга, нийтлэг стандартад нийцүүлэн тавиагүй

Тусгай сангууд нь тусдаа регистер байхгүй байгаа тул Shilendans.gov.mn нэгдсэн сайтад тусгай сангуудын мэдээллийг оруулах боломжгүй байна. Иймд ОНХС-ийн тоо мэдээллийг одоогийн байдлаар нэгдсэн сайтад оруулаагүй байна. Гэхдээ байгууллага тус бүр ил тодын самбар болон сум, аймгийн вэб сайтад мэдээллээ тогтмол байршуулж хэвшсэн ба ОНХС-ийн санал асуулга, төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг Сангийн яамны mof.gov.mn вэб хуудасны “ОНХС” цэсэнд нилээд дэлгэрэнгүй оруулсан байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил дутагдлын талаарх мэдээллийг сумдын төсвийн ерөнхийлөн захирагч нарт мэдэгдэж, хэрэгжүүлж ажиллах талаар сум тус бүрт зөвлөмж өгч ажилласан болно.

Аудитаар нийт **5083,5** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс, **30,1** сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **2987,7** сая төгрөгийн хариуцлага тооцох болон гэрээний хугацаанд ажлаа хийж дуусгаагүй, дутуу чанаргүй хийгдсэн ажлуудыг гүйцээж хийлгэх, өр, авлагыг бүртгэл тайланд тусгах албан шаардлага өгч ажилласан болно.


Санал асуулгын талаар: Нийцлийн аудитын хүрээнд нийт 24 сумдын 770 хүнийг хамруулан ОНХС-ийн хэрэгжилтийн гүйцэтгэлийн талаар ард иргэд ямар мэдээлэлтэй байгаа талаар санал асуулга авсан болно. Санал асуулгын дүн дараах байдалтай гарч байна. Үүнд:

- 1. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтын ямар төсөл арга хэмжээ Танай хороо,сум, дүүрэгт хэрэгжиж буй талаар та хэр мэдээлэлтэй байна вэ?**



ОНХС-ийн төлөвлөгөө гүйцэтгэлийн талаар ил тод мэдээлэх тал дээр сум орон нутагт хангалттай ажил зохион байгуулсан ба иргэд хүсвэл мэдээллийн бүх сувгаар мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн байна. Тухайлбал: *Бүх сум интернэтийн сүлжээтэй болсон ба онлайнаар мэдээлэл авах боломж бүрдсэн гэж үзэж байна.* Энэ байдал нь санал асуулгын дүнгээр ч нотлогдож байна. Нийт санал асуулгад оролцсон иргэдийн 52% нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих ажлын жагсаалтын талаар тодорхой мэдээлэлтэй байдаг гэсэн хариулт өгч байна.

2. ОНХС-ийн асуудлыг хэлэлцэх баг, хорооны иргэдийн нийтийн хуралд та оролцож байсан уу?




ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажлын жагсаалт гаргах БИНХ-д та оролцож байгаа юу? гэсэн асуултанд санал асуултанд оролцсон иргэдийн 44% нь хааяа гэсэн хариултыг өгч байна. Энэ байдлаас харахад төрийн байгууллага албан хаагчдын зүгээс тухайн ажлыг хууль журмын дагуу зохион байгуулж байгаа боловч иргэд идэвхитэй оролцохгүй байгаа байдал ажиглагдаж байна. Мөн иргэдийн санал өгсөн байдалтай танилцахад тухайн орон нутагт ач холбогдол багатай, нийтийн эрх ашигт нийцээгүй

саналуудыг гаргаж байна. Нөгөө тодорхой нэг ажлыг дэмжих зорилгоор хүмүүсийг цуглуулах зэрэг сөрөг үр дагавар гарч байна. Иймд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих ажлын жагсаалтыг дан ганц иргэдийн саналд үндэслэх нь учир дутагдалтай байна.


3. Хэрвээ оролцож байсан бол зайлшгүй шаардлагатай асуудлуудыг иргэдээр хэлэлцүүлж чаддаг эсэх талаар таны бодол




4. ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр болсон төсөл арга хэмжээний талаар мэдээллийг зарладаг уу?



5. ОНХС-аас ямар төсөл арга хэмжээ санхүүжүүлэх боломжтой тухай мэдээлэл болон таны саналыг авах хуудас Танай өрхөд ирж байсан уу?



6. ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний хэрэгжилт, ашиглалтанд иргэд хяналт тавих бололцоо, механизм байгаа юу?



ДҮГНЭЛТ

1. ОНХС-ийн хөрөнгийг сумдын хүн амын тоо, хөгжлийн индекс, хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, татварын идэвхийг холбогдох байгууллагуудын гаргаж ирүүлсэн тооцоололд үндэслэн Төсвийн тухай хуулийн 59,2-т заасан харилцааг баримтлан тооцож, хуваарилсан байна.
2. УИХ болон Засгийн газрын зүгээс төсвийн жил дуусч байгаатай давхцуулан 2014.12.19-нд төсөвт тодотгол хийж байгаа нь цаг хугацааны хувьд орон нутагт дээрх шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллахад нилээд хүндрэл үзүүлж, ОНХС-д хасах тодотгол хийж чадаагүйгээс их хэмжээний өр үүссэн байна.
3. Аудитын явцад ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжсэн төсөл арга хэмжээг төлөвлөхөд иргэдийн санал өгч байгаа байдалтай танилцахад иргэдээс санал авах ажлыг аймаг, сум хууль, журмын дагуу зохион байгуулж байгаа боловч тухайн орон нутагт ач холбогдол багатай, иргэдийн нийтлэг эрх ашиг, орон нутгийн хөгжлийн хөтөлбөр төлөвлөгөөнд нийцэхгүй саналуудыг иргэд гаргаж байна. Нөгөө талаар тухайн нэг ажлыг дэмжүүлэх зорилгоор иргэдийн саналыг авч төсвийн төлөвлөгөөнд тусгах сөрөг үр дагавар үүсч байна.
4. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний зураг төсөв, ТЭЗҮ-ийг бодитой хийгээгүй, иргэдийн нийтлэг эрх ашигт нийцээгүй, тухайн орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй уялдаагүй, ажлуудыг жагсаалтанд оруулж ИТХ-аар баталсан байна.
5. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг, хууль журмын дагуу зохион байгуулсан байна.
6. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг хянаж үзэхэд зөрчил дутагдал нилээдгүй байгаа нь төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо сул, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа “ажлын хэсэг” болон “төслийн менежер”-ийн багуудын ажил хангалтгүй байгааг харуулж байна.
7. Шат шатны ИТХ-ын дэргэд Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Заавар”-ын дагуу “Хяналтын хороо” байгуулж, ОНХС-ийн гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийх ажил хангалтгүй байна.
8. Тухайн жилд батлагдсан ОНХС-ийн хөрөнгөнд удаа дараа тодотгол хийж байгаагаас ард иргэдийн саналаар дэмжигдсэн ажлуудыг бүрэн хийж чадахгүй байгаа, нөгөө талаас гүйцэтгэгчээр шалгаран ажлаа хийсэн аж ахуйн нэгжүүдэд шаардлагатай санхүүжилтыг гэрээнд заасан хугацаандаа өгч чадахгүй

байгаагаас ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажил, арга хэмжээнд цаашид ард иргэд итгэл алдрах байдал ажиглагдаж байна.

9. Орон нутагт төсөвт өртөг, ажлын тоо хэмжээ багатай ажлуудад зураг, төсөв, техник эдийн засгийн үндэслэлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн компани олдохгүй, алслагдсан сумдад тусгай зөвшөөрөл шаардлагатай ажлуудад тухайн чиглэлээр мэргэжлийн зөвшөөрөлтэй компани, ААН-үүд очиж ажил гүйцэтгэхгүй хүндрэл учирч байна.
10. ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтын үйл ажиллагааг ил тод нээлттэй мэдээлж байгаа боловч, shilendans.gov.mn нэгдсэн сайтад мэдээлэл тавих боломжийг бүрдүүлээгүй байна.
11. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг төсвийн байгууллагуудын хүрээнд шалгаж үзэхэд мэдээллийг байгууллагын ил тодын самбар, өөрийн вэбсайтад байршуулсан боловч shilendans.gov.mn нэгдсэн вэб хуудсанд Засгийн газрын 2014 оны 384 тоот тогтоолоор батлагдсан “Журам”-д заасан агуулга, нийтлэг стандартын дагуу мэдээлэл тавьж хэвшээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах албан тушаалтнуудад доорх зөвлөмжийг хүргүүлж байна.

УИХ, Засгийн газарт:

- ОНХС-ийн тухайн жилд батлагдсан төсөвт тодотгол хийхгүй байх
- Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолоор “Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10,0 сая төгрөг, суманд 5,0 сая төгрөг байхаар тогтоосон” бөгөөд энэхүү заалтыг орон нутагт хэрэгжүүлэхэд хүндэрлэтэй байгаа тул тогтоолд өөрчлөлт оруулах,
- Орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг тусган батлаж байгаа шат шатны иргэдийн хурал, түүний төлөөлөгч нарт хариуцлага тооцох эрх зүйн орчныг бүрдүүлэх

Аймгийн ИТХ-ын дарга Т.Болдбаатарт:

- Шат шатны ИТХ-ын дэргэд ОНХС-ийн гүйцэтгэлд хяналт, үнэлгээ хийх “Хяналтын хороо”-г байгуулж, “ОНХС-ийн заавар”-ын дагуу ажиллуулах тал дээр анхаарч ажиллах
- Дээд шатны байгууллагаас аймгийн төсөвт тодотгол хийсэн тухай бүрт төсөвт тодотгол хийх ажлыг шуурхай зохион байгуулж хэвших
- ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлэж, бүртгэлд тусгуулах

Аймгийн Засаг дарга А. Эрдэнэбаатарт:

- Аймгийн ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллаагүй ажлын хэсгийн гишүүд, болон холбогдох төрийн албан хаагч нарт хариуцлага тооцож ажиллах
- МУЗЗНДНТУТХ-ын 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасан “тухайн Хурал Үндсэн хууль, бусад хууль тогтоомж зөрчсөн, эсхүл өөрийнх нь бүрэн эрхэд үл хамаарах, түүнчлэн хэрэгжих санхүүгийн болон бусад эх үүсвэргүй шийдвэр гаргасан бол Засаг дарга холбогдох шийдвэрт бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эрхтэй” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Х.Ган-Очирт:

- ТЭЗҮ, баталагдсан зураг, төсөвтэй ажлуудыг жагсаалтанд оруулж, ИТХ-аар хэлэлцүүлж байх

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих ажлыг ард иргэдээр хэлэлцүүлэх ажлыг хууль, журмын холбогдох заалтуудын дагуу явуулж, баримт материалуудыг бодит байдалд нийцүүлэн бүрдүүлж, архивын нэгж болгох

Аймгийн СТСХ-ийн дарга Г.Сувдад:

- ОНХС-ийн нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС-ын дагуу бүртгэж тайлагнаж, ОНХС-д үүссэн өр, авлагыг бодитоор илэрхийлж байх

Сумдын Засаг дарга нарт:

- ТЭЗҮ, баталагдсан зураг, төсөвтэй ажлуудыг жагсаалтанд оруулж, ИТХ-аар хэлэлцүүлж байх
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллаж байх
- Сангийн сайдын 2014.3.6-ны өдрийн 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг хэрэгжүүлж ажиллах,
- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-д нийцүүлэн санхүүжилтыг олгож байх
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан ашигтай нөхцлүүдийг тендерийн бичиг баримтад тусгаж, гэрээний тусгай нөхцлөөр батлан хэрэгжүүлж байх
- Зураг, төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод магадлашгүй ажлын зардал, хяналтын зардлыг бүрэн тусгаж байх
- Тухайн жилийн төсвийн зарлагаас давсан орлогыг дараа онд ОНХС-ийн эх үүсвэр болгож, төлөвлөж байх
- Инженерийн хийцтэй барилга байгууламж, төсөл арга хэмжээний зургийн даалгаврыг эрх бүхий байгууллагаар хянуулж, баталгаажуулж байх, мөн барилга байгууламжийн гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хяналт тавьж, ажил хүлээн авах комисст мэргэжлийн байгууллагыг оролцуулах
- МУЗЗНДНТУТХ-ын 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасан “тухайн Хурал Үндсэн хууль, бусад хууль тогтоомж зөрчсөн, эсхүл өөрийнх нь бүрэн эрхэд үл хамаарах, түүнчлэн хэрэгжих санхүүгийн болон бусад эх үүсвэргүй шийдвэр гаргасан бол Засаг дарга холбогдох шийдвэрт бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эрхтэй” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.



48723. *Moringa Xanthocarpa* nayar

Year: 2023

2015. 05. 12 № 6/10/9

1999

Санал хүргүүлэх тухай

Бидний саналыг хүлээн авч тайланд тусгана гэдэгт найдаж байна.

Бид жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахдаа Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүртгэхээр төлөвлөсөн боловч нягтлан бодох бүртгэлийн дансны бичилт хийх боломжгүй байсан. Уг асуудлыг Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газарт хүргүүлсэн боловч хариу өнөөдрийг хүртэл ирээгүй байна. Ер нь нийслэл болон бүх аймгууд дээрх өрийг тайлан балансаадаа тусгааргүй байгаа.

2. Тайлангийн төслийн хуудас 9-д "... хөгжлийн бодлогын хэлтэс нь нийт сумдад аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх санал асуулгыг зохион байгуулах үүрэг даалгаварыг албан тоотоор хүргүүлж 16 сум санал асуулгыг зохион байгуулж манайд албан тоотоор хариуг ирүүлсэн. Иймд дээрх сумдын санал асуулгыг баримтаар нотлогдохгүй байгаа гэж үзэх нь учир дутагдалтай юм.

Мөрөн суманд баригдсан хатуу хучилттай авто замуудын техник эдийн засгийн үндэслэл, зураг төсвийг УБ хот дахь "Классик роуд" ХХК хийж гүйцэтгэсэн. Авто замын даргын 2011 оны А/55 дугаар тушаалд "Зам гүүрийн зураг төсөлд бага хэмжээний өөрчлөлт оруулах эрхийг дотоодын зөвлөх компаниудад олгосон байдаг бөгөөд энэхүү өөрчлөлтийг зөвлөх компани саналаар "Классик роуд" ХХК өөрчилсөн. Өөрчилсөн зорилго нь тухайн замын чанар ашиглалтын хугацааг уртасгах болон траст дайралдсан айл, өрх аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгө эд хогшил, тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлэхээс зайлсхийж, хөрөнгө зардал, цаг хугацаа хэмнэх болно. Мөн Барилгын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалтын дагуу "... барилгын хөрөнгө оруулагч, захиалагч, гүйцэтгэгчийн хүсэлтээр норм, дүрмийн шаардлагын хүрээнд зураг төсөлд өөрчлөлт оруулах" зохиогч нь өөрийн эрхийн хүрээнд өөрчлөлт оруулсан гэдгийг тэмдэглэе.

Авто замын газрын даргын 2011 оны А/55 дугаар тушаалыг хавсарган хүргүүлэв.

04 0022

Мөрөн сумын өндөр хүчин чадалтай камерийн ажлын санхүүжилт нэмэгдээгүй бөгөөд гэрээг анхны техник эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн дагуу байгуулж Улсын комисс ашиглалтанд хүлээн авсан. Ашиглалтын явцад Цагдаагийн газарт төхөөрөмж байрлуулсан өрөөг зориулалтын дагуу засаж сайжруулах зайлшгүй шаардлага гарч Цагдаагийн газраас ирсэн хүсэлт тооцооллыг үндэслэн шинээр эх үүсвэрийг баталсан.

4. Тайлангийн төслийн хуудас 17-д "... замын урт өргөнийг хасах өөрчлөлтийг гүйцэтгэлийн явцад хийж, төсөвт өртөгт багтаасан байна" гэж дүгнэсэн. *Тайлбар 3-ыг анхаарна уу.*

5. Тайлангийн төслийн хуудас 20-д "... энэ худалдан авах ажиллагааг шууд гэрээ байгуулах замаар зохион байгуулж явуулах сонирхол их байгааг харуулж байна". *Энэхүү дүгнэлтийг эргэн харна уу.*

6. Тайлангийн төслийн хуудас 21-д "...бүртгэл тайланд тусгаагүй өр авлагатай холбоотой нийт 1,2 тэрбум төгрөгний зөрчил илэрч байна". *Санал 1-ийн дагуу зөрчил гэж дүгнэлтэнд оруулахгүйгээр нийт зөрчлөөс хасч өгнө үү. Гэхдээ бид 1,2 тэрбум төгрөгний алдааг огт үгүйсгээгүй бөгөөд цаашид онцгой анхааран нягтлан бодох бүртгэлийн хууль дүрэм, Сангийн яам, танай байгууллагын заавар зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах болно.*

7. Тайлангийн төслийн хуудас 25-д "... аудитын хугацаанд мэргэжлийн байгууллагын тус байгууламж дээр ажиллахад одоогийн байдлаар ашиглалтын шаардлага хангахгүй байна гэсэн дүгнэлтийг хийж байна".

Аудитын явцад Нэгдсэн эмнэлгийн хог хаягдлын байгууламжийн барилгын ажлыг бүрэн дуусгаж, Нэгдсэн эмнэлэгт хүлээлгэн өгсөн байна. Иймд энэ ажлыг аудитын явцад дуусгасан гэсэн байдлаар оруулж өгнө үү.

8. Тайлангийн төслийн хуудас 34-д "... ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлийг бодитой хийгээгүй, иргэдийн нийтлэг эрх ашигт нийцээгүй, тухайн орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй уялдаагүй, ажлуудыг жагсаалтанд оруулж ИТХ-аар баталсан байна".

Энэхүү зөрчил нь аймгийн ОНХС-гийн төлөвлөлтөнд хамааралгүй бөгөөд сумдад ч гэсэн нийтлэг биш юмаа. Иймд зарим сумдад гэсэн байдлаар дүгнэлтийг өөрчилнө үү.

ДАРГА



Х.ГАН-ОЧИР

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Аймгийн Аудитын газрын гүйцэтгэсэн “ОНХС-ийн 2014 оны зарцуулалтын байдал”-хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй холбогдох байгууллага албан тушаалтанууд танилцаж, 2015.05.12-ны өдрийн 6/1019 тоот албан тоотоор санал ирүүлсэн болно. Ирүүлсэн саналтай холбогдуулан 2015.05.13-ны өдөр тэргүүлэх аудиторын өрөөнд холбогдох албан тушаалтнуудыг байцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, асуудалтай зүйлүүдийг эцсийн байдлаар ярилцаж, тайлабар хийсэн.

Мөн удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн тайланд өөрчлөлт оруулахгүйгээр шийдвэрлэсэн болно.